



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/309

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "в", 29.2, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.3, 24 дүгээр зүйлийн 24.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит IX хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 98 жил, аймаг байгуулагдсаны 88 жилийн ойн Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны замын нөхцөл байдал, усархаг бороо орж үерийн усны улмаас хүндэрсэн тул зам засварын зардалд 5.000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн замын сангийн хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Х.Ган-Очир, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувд, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Аззаяа нарт зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД